

Агуулга

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төслийн нэр	2
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	2
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ	3
2.1 Төслийн талбайн байршил	3
2.2 Төсөл хэрэгжих талбайн өнөөгийн төлөв байдал	4
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	10
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	17
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
БҮЛЭГ 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
БҮЛЭГ 8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
БҮЛЭГ 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	24
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ	27

Хүснэгт

Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	2
Хүснэгт 2 Төслийн талбайн солбицол	3
Хүснэгт 3 Төслийн болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим	14
Хүснэгт 4 Нөлөөллийн эрчим, цар хүрээ, шинж чанараар ангилсан байдал	15

Зураг

Зураг 1 Төслийн талбайн сансарын зураг	2
Зураг 2 Төслийн талбайн байрзүйн зураг	3
Зураг 3 Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн зураг	4
Зураг 4 Төслийн талбайн ургамлан нөмрөг	6
Зураг 5 Төслийн талбайн нөлөөллийн эх үүсвэр ба нөлөөллийн бүс	10

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


1.1 Төслийн нэр

Төслийн зорилго: Хайлуур жоншны ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах төслийн зорилго нь ордын нөөцийг бүрэн ашиглаж, уул уурхайн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, экспортын чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн дэд бүтэц болон эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ олборлолтын үйл ажиллагааг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, байгаль орчны хамгааллын шаардлагад нийцүүлэн үр ашигтай зохион байгуулахад оршино.

1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Галзoo хан” ХХК
Төслийн нэр	“Бумбат-II” хайлуур жоншны ордын “Улаан-өндөр”-ийн ил далд аргаар ашиглах төсөл.
Улсын бүртгэлийн дугаар	9011115093
Регистрийн дугаар	5162696
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-023199
Хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 1-р хороо Их хуралдай бизнес төв 908 тоот
Утас	77112428



Зураг 1 Төслийн талбайн сансарын зураг

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ


2.1 Төслийн талбайн байршил

Бумбат-2 хайлуур жоншны ордын “Улаан-өндөр”-ийн хэсэг нь засаг захиргааны хувьд Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутагт орших бөгөөд УБ хотоос зүүн урагш 310 км-т, Дорноговь аймгийн Айраг сум-аас баруун тийш 140 км, Дундговь аймгийн Говь-Угтаал сумын төвөөс зүүн өмнө зүгт 22 км-т тус тус оршино. Нийт 585.26 га талбайн нь L-48-84 тоот хавтгайд байрлана.

Талбайн хэмжээ: 585.26 га

Хүснэгт 2 Төслийн талбайн солбицол

№	Газрын зөвшөөрөл	Уртраг			Өргөрөг		
		градус	минут	секунд	градус	Минут	секунд
1	MV-023199 тоот тусгай зөвшөөрөл	107	41	31.5	45	49	1.6
2		107	41	31.49	45	47	31.6
3		107	39	51.54	45	47	31.6
4		107	39	51.54	45	48	18.61
5		107	40	58.55	45	48	18.61
6		107	40	58.55	45	48	41.61
7		107	40	15.05	45	48	41.61
8		107	40	15.05	45	48	57.61
9		107	39	51.55	45	48	57.61
10		107	39	51.55	45	48	21.61
11		107	39	39.81	45	48	21.61
12		107	39	1.52	45	48	41.61
13		107	39	51.5	45	49	23.25
14		107	39	51.5	45	49	1.61




Зураг 2 Төслийн талбайн байрзүйн зураг

2.2 Төсөл хэрэгжих талбайн өнөөгийн төлөв байдал

“Галзoo хан” ХХК нь Ашигт Малтмал Газрын Тосны Газраас 2025 оны 12 сарын 09-ний өдөр MV-023199 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Бумбат-II” хайлуур жоншны ордын “Улаан-өндөр”-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаанд олгосон. Төслийн талбайд өнөөгийн байдлаар ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байна.

Төсөл хэрэгжих талбайн газрын гадарга: Судалгааны талбай нь нийт 585.2 га газрыг хамрах бөгөөд талбайн хүрээнд нам толгодын бэл хормой, жижиг ам хөндий бүхий гадарга нь гуу жалгын хэрчигдэл дунд зэрэг, толгод хоорондох нарийн хуурай сайрууд, тэгшивтэр хөндий зэрэг гадаргын олон янзын хэлбэрийг хамарч д.т.д 1240-1310м өндөрт байрлана. Судалгаанд хамрагдсан талбайд Монгол орны хөрсний ангиллаар Цайвархүрэн хөрсний дэд хэв шинжид багтах чулуурхаг, сайргархаг төрлийн хөрснүүд дангаараа болон бүрдэл байдлаар тархсан байна. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин бага, шимт үе давхарга нь нимгэндүү (0-20 см), жижиг бөөмөрхөг болон үйрмэг бүтэцтэй, механик нөлөөлөлд дунд зэрэг тэсвэртэй, байгалийн аясаараа нөхөн сэргэх чадамж сулавтар байдаг онцлогтой. Мөн сайргархаг, том ширхэгтэй элсний агууламж өндөртэй байна. Хөрсний үе давхарга нь ихэвчлэн А-ВС-С гэсэн дараалалтай, хөрсний дээд үе давхаргын (0-30 см) ялзмагийн агууламж 1.1-1.4%, элсэрхэг биш хөрсний бүх үе давхарга карбонатжилттай, урвалын орчин 7.8-8.0 буюу дунд зэрэг шүлтлэг, хялбар уусах давсжилт маш бага буюу 0.04-0.13 dS/m байна. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд том ширхэгтэй элсэн фракц зонхилсон элсэнцэр бүрэлдэхүүнтэй. Нөлөөлөлд

өртөөгүй ердийн хөрсний өнгөн үе давхарга дахь хортой болон био-идэвхт хүнд металлын агууламж стандартын хүлцэх агууламжаас ноцтой хэтэрсэн тохиолдол байхгүй хэвийн түвшинд байна.




Зураг 3 Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн зураг

Ургамлан бүрхэвч: Дундговь аймгийн Говь - Угтаал сумын нутагт байрлах төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дорнод говийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Тойрогт Говь-Алтайн нурууны зүүн шувтаргын уулсын араар, дорно зүгт ухаа гүвээрхэг, тэгш гадаргатай Дорноговь, Дундговь аймгийн өмнөд, Өмнөговь аймгийн зүүн ба хойд хэсгийг хамаарна. Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог нь нийт 480 зүйлтэй ба жинхэнэ говийн цөлөрхөг хээр, цөлийн төлөөлөгчдөөс бүрдсэн бөгөөд зөвхөн энд ургадаг 9 зүйл тохиолдоно.

Тойргийн үндсэн төрхийг үзүүлэх ургамлуудад:: Одой хайлас (*Ulmus pumila*), Монгол бүйлэс (*Amygdalus mongolica*), Нангиад зээргэнэ (*Ephedra sinica*), Төвд харгана (*Caragana tibetica*), Федианы аргамжинцэцэг (*Cistanche feddiana*), Говийн хялгана (*Stipa gobica*), Сайрын хялгана (*Stipa glauca*), Хөмүүл (*Allium mongolicum*), Таана (*Allium polyrhizum*), Сибирь шорной (*Atriplex sibirica*), Эрлийз лууль (*Chenopodium hybridum*), Орог тэсэг (*Krascheninnikovia ceratoides*), Монгол хамхуул (*Corispermum mongolicum*), Сибирь хармаг (*Nitraria sibirica*), Үслиг манан хамхаг (*Bassia dasyphylla*), Дэлхээ тогторгоно, (*Kochia prostrata*), Каспийн шарбударгана (*Kalidium gracile*), Паульсын бударгана (*Salsola paulsenii*), Зүүнгарын улаанбударгана (*Reaumuria soongorica*), Толгодын бударгана (*Salsola collina*), Монгол Потанин (*Potania mongolica*), Говийн бэрмэг (*Limonium gobicum*), Шинэсэрхүү бударгана (*Salsola laricifolia*), Потанины хотир (*Zygophyllum potaninii*), Монгол ямаалж (*Tragus mongolicum*), Говийн тост (*Brachanthemum gobicum*), Грубовын ортууз (*Oxytropis grubovii*), Цөлийн тайр (*Gypsophila desertorum*), Монгол шарилж (*Artemisia mongolorum*), Монгол чоногоно (*Jurinea mongolica*), Монгол шардалан (*Tugarinovia mongolica*), Төлөгчдүү боролз (*Ajania achilleoides*) зэрэг болно.

Төслийн үйл ажиллагаа эхлээд барилга байгууламж угсарах ажил эхэлсэн байсан. Ургамлан нөмрөгийн судалгааг хийхдээ төслийн талбайн орчимд нийт 3 цэгт бүрэн бичиглэл хийж зүйлийн бүрэлдэхүүн, ургамлан бүрхэвч, биомасс зэргийг тодорхойллоо. Төслийн талбай болон тухайн орчмын нутаг дэвсгэр нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө цөлөрхөг хээрийн ургамалжилтай бөгөөд бүхэлдээ 1 хэв шинжид хамаарах 2 бүлгэмдэл тархсан байна. Барилга байгууламж барьсан хэсэг, барилгын материал хураасан хэсэг, зам, кемпийн ургамлан нөмрөг устсан бөгөөд байгаийн аяасаараа нөхөн сэргэж байна.

**“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ
“БУМБАТ-II” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “УЛААН-ӨНДӨР”-ИЙН ИЛ ДАЛД АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 4 Төслийн талбайн ургамлан нөмрөг

Уул зүй: Дундговь аймаг нь Монгол улсын нутгийн төв хэсэгт талархаг нутагт говь хээрийн бүсийн зааг дээр оршдог. Нутгийн хамгийн өндөр цэг нь 1926 м өндөр, Дэлгэрхангай уул юм. Мөн Их, Бага газрын чулуу зэрэг уулс бий. Нутгийн хойд хэсэгт дээд палеозойн хурдас, өмнөд хэсгээр нь цэрдийн ба кайнозойн хурдас тархжээ. Дундговь аймгийн нутагт Онгийн голоос өөр том гол, нуур байхгүй. Тогоогийн, Дүүрэн Харганын, Олгой нуурын зэрэг рашаан бий.

Уур амьсгал: Хамгийн хүйтэн 1 дүгээр сард агаарын дундаж температур -16.7...-19.6°C байхад агаарын үнэмлэхүй хамгийн бага -39.7°C 1981 онд Сайхан-овоо өртөөнд ажиглагдсан байдаг. Хамгийн дулаан 7 дугаар сард агаарын температур 19.9...22.3°C байхад агаарын үнэмлэхүй их температур 41.3°C Гурвансайхан өртөөн дээр 1999 онд ажиглагдсан байдаг байна. Хур тунадасны хувьд жилийн нийлбэр хур тунадас 110.6...139.0мм бөгөөд өвлийн улиралд 3.3...3.8мм, хаврын улиралд 11.7...16.4мм, зуны улиралд 77.1...102.3мм, намрын улиралд 15.1...18.1мм –ийн хооронд хэлбэлзэнэ.

Амьтны аймаг: Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутаг нь монгол орны физик газарзүйн мужлалаар (Цэгмид, 1969; Грубов, 1982) Дорнод говийн мужид хамаарагдана. Энэ бүс нутаг нь талын ландшафттай тул тал хээр, говь цөлийн амьтны

аймаг зонхилно.

ХӨХТӨН: Нийт 6 багийн 33 зүйл хөхтөн амьтан тохиолдох боломжтой болохыг тодруулж тэдгээрийн хамгааллын статусыг тодорхойлов. Одоогоор тус бүс нутгийн хөхт амьтдын тоо толгой, тархалт харьцангуй хэвийн байна. Амьтны тухай хуулиар “нэн ховор” амьтны жагсаалтад орсон зүйл байхгүй харин ховор амьтны жагсаалтад 3 зүйл (эрээн хүрнэ, аргаль, янгир), МУ-ын Улаан номд (2014) 3 зүйл бүртгэгдсэн. Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн II хавсралтад аргаль, мануул, шилүүс, саарал чоно гэсэн 4 зүйл тус тус орсон. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцын II хавсралтад аргаль, хар сүүлтийн орсон. Монгол улсын хөхтөн амьтны Улаан дансанд Бүс нутгийн үнэлгээгээр устаж болзошгүй (EN) аргаль хонь, цагаан зээр, “Ховордож болзошгүй” ангиллаар саарал чоно, шар үнэг, хярс үнэг, мануул, шилүүс, янгир оржээ.

Тусгай хамгаалалттай газар нутага: MV-023199 тоот тусгай зөвшөөрөлтэй “Бумбат-II хайлуур жоншны ордын “Улаан-өндөр”-ийн ил, далд аргаар ашиглах төсөл нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.

Түүх соёлын өв: Дундговь аймагт Улсын хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх 6 дурсгал байна. Аймаг, нийслэлийн хамгаалалтанд байх түүх, соёлын үл хөдлөх 37 дурсгал байна. Үүнээс Говь-Угтаал суманд 3 дурсгал байна. Төслийн талбайтай аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал байхгүй байна.

Нийгэм эдийн засаг: Дундговь аймгийн Говь-Угтаал сум нь 1924онд байгуулагдсан, хуучнаар Сэцэн хан аймгийн Боржигон Сэцэн вангийн хошуу. Ажирхай, Морьт, Хонгор гэсэн 3 багийн нийт 498 өрхөд 1544 хүн амьдардаг. Хүн амын тоо жилээс жилд буурч байгаа нь Улаанбаатар хот, Говьсүмбэр аймагтай ойролцоо байршилтай, сумын газар нутгийн хэмжээ харьцангуй бага байдгаас отрын нөөц бэлчээр хомстой холбоотой. Олон малтай айл ялангуяа адуу оторлох зорилгоор бусад аймаг сумдад шилжин суурьших явдал ихэссээр байна. Говь-Угтаал сум нь далайн түвшнээс дээш 1450-1705 м өргөгдсөн өндөрлөг уул толгодтой Монгол оны тал хээрийн бүсэд хамаарагддаг бөгөөд элстэй чулуурхаг, хүрэн хужир мараат хөрстэй. Дов толгод, тал говирхог хөндий ихтэй нутаг. Физик газарзүйн хувьд Хэнтийн захын уулсын мужид, геоморфологийн хувьд Орхон-Сэлэнгийн бэсрэг уулсын мужийн Туулын дэд мужад багтдаг. Газар хөдлөлийн эрчим 7 балл. Дундговь аймгийн зүүн хэсэгт: Улаанбаатар хотоос 270 км, Аймгийн төвөөс 110 км зайд зүүн бүсийн сумдын төвд байрладаг. Говьсүмбэр аймгаас баруун тийш 85 км-т оршдог бөгөөд өөрийн аймгийн Цагаандэлгэр, Баянжаргалан, Дэрэн, Гурвансайхан сумдтай хиллэдэг.

Газрын гадарга, хэвлий: Гадаргуугийн хувьд далайн түшингээс дээш 1300-1500м

өргөгдсөн жижиг толгод гүвээ хэлбэрийн мөлгөржсөн хэсэгт багтан, Хэнтийн нурууны төгсгөл говийн бүсийн эхлэлийн зааг бүс хэсэгт оршдог. Хамгийн өндөр цэгүүд нь далайн түшингээс дээш 1505-1520 м-т өргөгдсөн Хараат, Бүс, Их дулаан, Их бичигтийн товгор уулс бөгөөд тэдгээр нь харьцангуй залуу гүний чулуулгаас тогтох учир барзгар гадаргуутай, эргэн тойрон 20-50км зайд харагдалт сайтай байдаг. Урагшлах тутам газрын гадаргуу намсаж, мөлгөржин жижиг гүвээ, толгод болон хувирдаг ба харьцангуй өндөржилт нь 10-50 м-ээс хэтэрдэггүй. Судалгааны талбай нь тал хээрийн жижиг уулархаг мужид хамаардаг. Нутгийн сүсэг бишрэлт Дархан хан, Хундар, Их Өлгий зэрэг 10 гаруй тахилгат уул далайн түвшнээс дээш 1224-1317 метр өргөгдсөн. Тусгай зөвшөөрлийн талбайд дунджаар 1000-1200 м үнэмлэхүй өндөртэй 100м, 200м харьцангуй өндөртэй, бөмбөгөр оройтой, налуу хажуутай цав толгод, ухаа гүвээ, далан хярууд зонхилно. Талбайн зүүн хойд хэсэгт 1180 м үнэмлэхүй өндөртэй тоот өндөрлөг оршино. Тухайн талбайд уулын дээд хэсгээс нурж ёроолд нь хуримтлагдсан чулуу шороог урсгаж зайлуулах гол, горхи байхгүй тул тэр зүйлс дороо хуримтлагдсаар үндсэн уулын хажууг хучсан байдаг.

Геологийн тогтоц ба геоморфологи: Бумбат-II хайлуур жоншны ордын дүүрэгт доод пермийн Сахлайн гол, доод-дунд юрийн Холбоо хонгор, доод цэрдийн Шинэ худаг формацын тунамал-вулканоген хурдас хуримтлал тархжээ. Эдгээр хурдас чулуулгууд нь орчин үеийн сэвгэр хурдсаар хучигдахын зэрэгцээ хожуу триас-түрүү юрийн Бор-Өндөр, Мандалговь бүрдэл түрж гарсан байна. Доод пермийн хурдас нь бүхэлдээ галт уулын-гаралтай бөгөөд антиклиналь, синклиналь атираа үүсгэн, зах нь 30-45°-ын унал үүсгэдэг. Илэрц сайтай зузаан, давхарга гадаргуу үүсгэдэг, агаарын зураг дээр-зууван бүдэг саарал өнгө үзүүлдэг ба дээд давхаргын хурдас чулуулаг нь доод - давхаргынхаасаа арай цайвар харагддаг. 1983 онд Л.В.Заботкин нар Сахал голын нэрээр ялгасан. Хэрлэнгийн массив Идэрмэгийн блокын хэмжээнд Дундговь аймгийн Луус сумын Сахал гол, Мандалговь уул зэрэг газарт тархсан. Сизуралын Их хад формацыг нийцлэг хучиж, дунд пермийн Сант, Дэлгэрхангай, Онгон-Овоо формацуудаар үл нийцлэг хучигддаг. Тулгуур зүсэлтийг Сахлайн голын баруун эрэг, Бага хийд уулын орчим, Ганжуур жасаас зүүн тийш 4 км-т тус тус ялгажээ. Дотор нь дацит болон риолитын мэмбэрүүдэд хуваагдана. Риолит мэмбэр нь (Ра) нь Энэ мэмбэрийн хурдсанд риолит, риодацит, трахириолит, дацит, тэдгээрийн туфууд, конгломерат, элсжин, алевролит, аргиллит зэрэг чулуулаг нь туфоген-вулканоген хурдсаас илүү хүчиллэг найрлагатай мөн тунамал чулуулгийн оролцоо ихтэйгээрээ ялгаатай, тунамал хурдасны нарийн үеүдээс тогтоно. Дациг мэмбэр: Энэ мэмбарийн хурдсын ихэнх нь дацит, трахидацит риодацитын найрлагатай лаав, туф, игнимбрит байх бөгөөд риолит, андезит, трахиандезитын найрлагатай туф, лаав ховор


тохиолдоно. Тунамал чулуулгаас элсжин, алевролит, туфконгломератын нарийн үе, мэшил байдлаар хааяа тохиолдоно Тухайн судалгааны талбай нь Ази тивийн усны хагалбарын дагуу оршдог, эх газрын эрс тэс уур амьсгалтай, геологийн хөгжлийн хувьд 2 том структурын дунд орших идэвхтэй бүсэд харьяалагддаг зэрэг онцлогоос хамаарч өөрийн гэсэн онцлогтой хөгжлийг туулж байгаа учир геоморфологийн хувьд өөрийн зүй тогтлыг үүсгэн хөгжиж байна. Талбай нь кайнозойн галав, неогены насны цаг үед харьцангуй тайвширч, нүцгэрэл, тэгшрэлийн цаг үе эхэлсэн нь энэ нутгийн онцлог үе болж байна.

Гадаргын болон газрын доорх ус: Энэ бүс нутагт гадаргын ус нэн ховор. Сав газрын баруун хойд хэсгээр (Өвөрхангай аймаг) Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамрагдах гол цөөн тоотой бий. Харин говийн бүсэд түр зуурын уруйн ус урсах хуурай сайрууд маш түгээмэл ажиглагддаг. Тус сав газар нь говийн бүсэд хамаардаг, говь хээр хосолсон эх газрын эрс тэс уур амьсгалтай, зуны улиралд +41 хэм хүртэл халж, өвлийн улиралд -40 хэм хүртэл хүйтэрдэг. Салхины дундаж хурд 4.2-4.6 м/сек, зарим үед 35 м/сек хүртэл ширүүсдэг, салхи ихтэй, өдөр шөнийн агаарын хэмийн ялгаа их нутаг юм. Бүс нутгийн хөрсөн бүрхэвчинд хээрийн бор хөрс, цөлийн бор саарал хөрс гол суурийг эзэлнэ. Цөлөрхөг хээрийн бор хөрс– энэ хэв шинжийн хөрсөнд агь-хазаар өвс-говийн хялганат, таана-говийн хялганат, хазаар өвс-говийн хялганат, баглуур-таана-говийн хялганат бүлгэмдэл бүхий 15-25% бүрхэцтэй цөлөрхөг хээрийн ургамлын бүлгэмдэл ургах нь элбэг. Умард говийн усны сав газар нь 8 аймаг, 59 сум, Нийслэлийн Багахангай дүүргийн газар нутгийг хамарсан нийт 180404.2 км² талбай бүхий говь, хээрийн бүсүүдийг хамарсан өргөн уудам нутаг юм. Умард говийн усны сав газарт Дундговь аймгийн 92.7 хувь, Говьсүмбэр аймгийн 70.9 хувь, Дорноговь аймгийн 37.3 хувь, Сүхбаатар аймгийн 31.6 хувь, Төв аймгийн газар нутгийн 25.9 хувь, Өвөрхангай аймгийн 14.0 хувь, Хэнтий аймгийн 6.8 хувь, Өмнөговь аймгийн 3.8 хувь тус тус хамрагдаж байна. Тус сав газар нь далайн төвшнөөс дээш дунджаар 1267 метр өргөгдсөн, баруунаас зүүн зах хүртэл 858 км урт, хойноос урагш 424 км өргөн, 2700 км хилийн цэсийн урттай нутаг хамаарах ба монгол орны бусад сав газруудаас талбайн хэмжээгээрээ 2 дугаарт ордог.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Галзоо хан” ХХК-ны Дундговь аймгийн Говь-Угтаал суман нутагт орших “Бумбат-II” нэртэй хайлуур жоншны ордын “Улаан-өндөр”-ийн ил далд аргаар ашиглах төслийн үйл ажиллагаа хэрэгжсэнээр тухайн бүс тодорхой хэмжээгээр элэгдэлд орно. Элэгдэл эвдрэлд оруулах гол хүчин зүйл нь хүнд даацын машины хөдөлгөөн, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үеийн тоос тоосонцор, дуу чимээ зэрэг юм.

Мөн төсөл хэрэгжсэнээр байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.



Зураг 5 Төслийн талбайн нөлөөллийн эх үүсвэр ба нөлөөллийн бүс

Агаарын чанар:

- Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх
- Хүдэр боловсруулах үед үүсэх тоосжилт
- Барилга байгууламжийн орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх

- Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- ✓ Машин техникийг тогтмол үзлэгт хамрагдуулж байх, янданд шүүлтүүр тавих
- ✓ Зам талбайг тогтмол усалж чийгшүүлж байх
- ✓ Ажилчдын амрах байр сууцны гадна талбайг зүлэгжүүлж тохижуулж агаарын чанарыг сайжруулах
- ✓ Хог хаягдлыг цаг тухай бүрд ачуулж, ангилах ялгаж байх
- ✓ Төсөл хэрэгжих бүхий хугацаанд агаарын тоос болон хорт бодисыг хэмжилтийн цэг бүр дээр тогтмол хийж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм

Хөрсөн бүрхэвч: Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- ✚ Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах
- ✚ Ачиж тээвэрлэх үеийн машин техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх
- ✚ Олон салаа зам гарган зорчих
- ✚ Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- ✚ Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- ✚ Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- ✓ Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- ✓ Олон салаа зам гаргахгүй байх, зам талбайн тэмдэгжүүлэлт хийх
- ✓ Уурхайн гадаад болон дотоод тээврийн замыг хатуу хучилттай болгох
- ✓ Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаях, цаг тухай бүрт ачуулах, ангилан ялгаж байх
- ✓ Цэвэрлэх байгууламж болон ариун цэврийн байгууламжийг байгаль ээлтэй технологийг сонгон ашиглах эдгээрийн эвдрэл гэмтлийг шалгаж байх

Гадаргын болон газрын доорх ус: “Бумбат-II” нэртэй хайлуур жоншны ордын “Улаан-өндөр”-ийн ил далд аргаар ашиглах төслийн гидрогеологийн судалгаагаар уурхайн ашиглалтын талбайд гүний уст цэг илрээгүй байна. Мөн унд ахуйн усны хэрэгцээг хангахын тулд шинэ худаг гаргахаар төлөвлөсөн. Төслийн талбайн ойр орчимд гол горхи, булаг шанд зэрэг гадаргын усны эх үүсвэр байхгүй байна. Иймд төсөл хэрэгжих явцад байгалийн усны нөөц болон усны бохирдолд үзүүлэх нөлөөлөл байхгүй юм. Гэвч ахуйн бохир ус болон хог хаягдлыг зөв байршуулаагүй мөн орчны цэвэрлэгээ хийгээгүйн улмаас гадаргын болон хөрсний усыг тодорхой

хэмжээгээр бохирдуулж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ:

- ✓ “Галзоо хан” ХХК нь цэвэрлэх байгууламж байгуулан шингэн хаягдлыг байгаль орчинд халгүй арга хэлбэрээр зайлуулах, дахин ашиглах арга хэмжээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн 2019 оны 05 сарын 02нд батлагдсан нэмэлт өөрчлөлтийг, Усны тухай хуулийн 3.1.32, 3.1.33, 25, MNS 4943:2015 стандарт, 2.2-2.4, 25 дугаар зүйлийн 25.1, 8 дугаар зүйл, зэргийг дагаж мөрдөнө ажиллахыг зөвлөж байна.

Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл: Ажиллагсдын ихэнх нь дуу чимээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй нөхцөлд ажиллахаар байгаа тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд хялбар өртөх магадлалтай юм. Түүнчлэн хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасны хангалт, ашиглалтад анхааралтай хандаагүйгээс үйлдвэрлэлийн осолд өртөх магадлалтай байна. Байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ:

- ✓ Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хугацаанд хамрагдуулж байх
- ✓ Эрүүл ахуй аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг өдөр бүр өгч байх
- ✓ Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон зориулалтын ажлын хувцсаар хангах
- ✓ Галын аюулгүй ажиллагаа болон гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахин мөрдүүлэх тал дээр хяналт тавих

Ургамлан нөмрөг: Хүнд машин техникийн хөдөлгөөнөөр орчны ургамлан бүрхэвч алдагдах, ажиллагсад зориудын бус замаар явах, анхаарал болгоомжгүйгээс гал түймэр гарах зэрэг нь ургамлан нөмрөгт нөлөөлөн, түүнийтөрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх), зэрэг сөрөг нөлөөллүүд үүсч болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ:

- ✓ Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- ✓ Амрах байрнаас хоолны газар хүрэх зам гэх мэт явган хүний замыг нэг маршрутаар болгож цементлэн хашиж аль болох унаган ургамлыг нь гэмтээхгүй байх
- ✓ Гадна талбайг тохижуулах хашиж хамгаалах, тогтмол усалж арчилж байх
- ✓ Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын зэрэг барилга байгууламжид галын аюулгүй ажиллагааны буланг хийх ажилчдад хэрэглэх заавар зөвлөгөө санамжийг тогтмол өгөх, сургалт зохион

байгуулах

Амьтны аймаг: Төслөөс амьтны аймагт нөлөөлөх шууд нөлөөлөл байхгүй. Төсөл хэрэгжих газар тээврийн хэрэгсэл, хүний хөдөлгөөн ихсэж, дуу чимээний нөлөөлөл зэргээс жижиг амьтад дайжих, амьдрах орчин хумигдсан. Харин ногоон байгууламжийг байгуулснаар төслийн ойр орчмын талбайд тархах зарим амьтдад амьдрахад эерэг нөлөөлөл үзүүлж болох юм.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ:

- ✓ Хөрсийг зүй зохистой ашиглах, олон салаа зам гаргахгүй байх, тогтсон нэг замаар тээврийн хэрэгслүүдийг зорчуулах.
- ✓ Ховор амьтадыг устахаас хамгаалж өөр газар шилжүүлэх болон биотехникийн арга хэмжээ авах талаар судалгаа хийх, шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгууллагын зөвлөмж авч хэрэгжүүлэх
- ✓ Уулын малталт, овоолгыг ан амьтанд аюулгүй байхаар байрлуулах
- ✓ Биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах

Нийгэм эдийн засаг: Төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага ба аливаа болзошгүй нөлөөлөл нь хүний анхаарал, болгоомжгүй, хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаална. Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмийн албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг улс болон орон нутгийн төсвийн санд оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр орон нутагт шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой юм. Аливаа төслийн үйл ажиллагаанаас тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал, нийгэм, эдийн засаг болон хүн амын амьдрах орчинд хэрхэн нөлөөлөх, тэдгээр нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил зэргийг тогтооход магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргыг өргөн хэрэглэдэг. Энэ арга нь экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлтүүдийг магадлалын онолд тулгуурлан боловсруудах замаар хэрэгждэг. Магадлан жагсаах арга нь нөлөөлөх зүйл байна, байхгүй гэсэн зарчмаар үнэлэх бөгөөд нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэнэ. Ингэхдээ уг үнэлгээнд оролцсон шинжээч, судлаачдын дүгнэлтийг үндэслэн 2 төрлийн жагсаалт гаргасан. Нөлөөллийн хэлбэр нь үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь “шууд”, “шууд бус”, “буцаж нөлөөлөх”, “буцалтгүй нөлөөлөх”, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд “богино хугацааны”, “урт хугацааны”, эрчмийн хувьд “бага зэрэг”, “дунд”, “хүчтэй” гэхчилэн ангилсан магадлах жагсаах аргаар тодорхойлсон. Доорх хүснэгтээр үзүүлэв.

**“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ
“БУМБАТ-II” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “УЛААН-ӨНДӨР”-ИЙН ИЛ ДАЛД АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 3 Төслийн болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл			Хугацаа		Давтамж		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зураг нөлөөлөх	Хүчтэй нөлөөлөх
Биологийн төрөл зүйлийн оршин амьдрах нөхцөл											
1	Газрын доорх усны чанар		x		x			x	x		
2	Газрын доорх усны нөөц		x			x		x	x		
3	Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x	x		x		
4	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x								
Байгаль орчны чанарын өөрчлөлт											
5	Усны чанар, хэмжээ		x		x		x			x	
6	Агаарын бохирдол		x		x			x	x		
7	Хөрсний бохирдол		x			x	x		x		
8	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл		x		x			x		x	
9	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	x							x		
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл											
10	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+		+		+	
11	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх										
12	Хүн, амын орлого нэмэгдэх	+				+		+		+	
13	Хүн амын тоо өөрчлөгдөх										
14	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+		+		+		+		+	
15	Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+			+
16	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+			+		+	+		
17	Ажлын байр нэмэгдэх	+				+	+			+	
18	Улирлынчанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+		+		+		
19	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x		x			x	

Тайлбар:

“+” эерэг, “х” сөрөг

**“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ
“БУМБАТ-II” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “УЛААН-ӨНДӨР”-ИЙН ИЛ ДАЛД АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 4 Нөлөөллийн эрчим, цар хүрээ, шинж чанараар ангилсан байдал

Шууд нөлөөллийн тоо: 8	
Эерэг нөлөөлөл нь: 6	Сөрөг нөлөөлөл нь: 2
– Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх – Хүн, амын орлого нэмэгдэх – Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх – Орон нутгийн орлого нэмэгдэх – Ажлын байр нэмэгдэх – Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	– Хөрсний элэгдэл, эвдрэл – Дуу чимээ, шуугианы нөлөө
Шууд бус нөлөөллийн тоо: 5	
Эерэг нөлөөлөл нь: 1	Сөрөг нөлөөлөл нь: 4
– Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	– Газрын доорх усны чанар – Усны чанар, хэмжээ – Агаарын бохирдол – Хөрсний бохирдол
Өөрөө зохицуулагдах нөлөөллийн тоо: 1	
Эерэг нөлөөлөл нь: 1	Сөрөг нөлөөлөл нь:
– Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	
Богино хугацааны нөлөөллийн тоо: 3	

Сөрөг нөлөөлөл нь: 2	Эерэг нөлөөлөл нь: 1
– Усны чанар, хэмжээ – Агаарын бохирдол	– Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
Урт хугацааны нөлөөллийн тоо : 9	
Сөрөг нөлөөлөл нь: 3	Эерэг нөлөөлөл нь: 6
– Газрын доорх усны чанар – Хөрсний элэгдэл, эвдрэл – Хөрсний бохирдол	– Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх – Хүн, амын орлого нэмэгдэх – Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх – Орон нутгийн орлого нэмэгдэх – Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох – Ажлын байр нэмэгдэх
Буцах нөлөөллийн тоо: 4	
Сөрөг нөлөөлөл нь: 2	Эерэг нөлөөлөл нь: 2
– Хөрсний элэгдэл, эвдрэл – Усны чанар, хэмжээ	– Ажлын байр нэмэгдэх – Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
Буцалтгүй нөлөөллийн тоо: 9	
Сөрөг нөлөөлөл нь: 4	Эерэг нөлөөлөл нь: 5

**“ГАЛЗОО ХАН ” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ
“БУМБАТ-II” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН “УЛААН-ӨНДӨР”-ИЙН ИЛ ДАЛД АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

– Газрын доорх усны чанар – Газрын доорх усны нөөц – Агаарын бохирдол	– Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх – Хүн, амын орлого нэмэгдэх – Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх – Орон нутгийн орлого нэмэгдэх – Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
Сулавтар нөлөөллийн тоо: 9	
Сөрөг нөлөөлөл нь: 7	Эерэг нөлөөлөл нь: 2
Эрчимтэй нөлөөллийн тоо : 1	
Сөрөг нөлөөлөл нь: 0	Эерэг нөлөөлөл нь: 1
	– Орон нутгийн орлого нэмэгдэх

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр тусгасан.

“Галзoo хан” ХХК нь Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутагт орших “Бумбат-II” нэртэй хайлуур жоншны ордын “Улаан-өндөр”-ийн ил далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, мөн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримтлан боловсруулсан.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2026 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 30,048,125 сая,мян/төг зарцуулахаар төсөвлөв. Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дугаар сарын 01-ний дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг 12 сарын 30-ны дотор холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ	БОМТ-ийн нийт зардал /мян.төг/,
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	23,278,500
Дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө	-
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,712,500
Түүх соёлын өвийг хамгалах төлөвлөгөө	-
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,166,500
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,890,625
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
Нийт	30,048,125

**“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БУМБАТ-II” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН
“УЛААН-ӨНДӨР”-ИЙН ИЛ ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн акт барим бичиг
Агаар										
1	Тээвэрлэлтийн үед	Уурхайн тээвэрлэлтийн үед тоос шороо агаарт босох	Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх	Төслийн талбайд	-	2,500	-	4.500.000	60 удаа	-MNS 0017-2-3-16:1988. Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам.
2	Тээвэрлэлтийн үед	уурхайн тээвэрлэлтийн үед тоос шороо босох	Тээвэрлэлтийн үед хурдын хязгаар тогтоох тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Төслийн талбайд	-	450,000	4 ш	1.800.000	Үйл ажиллагааны турш	-MNS 3384-1982. Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавигдах ерөнхий шаардлага.
3	Техник тоног төхөөрөмж ажиллах үед	Ашиглагдаж буй машин техникээс ялгарах утаа агаарт дэгдэх	Ашиглагдаж буй машин техникээс ялгарах утааг стандартын түвшинд байлгах анхаарч тогтмолүзлэг хийж ажиллах	Төслийн талбайд	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	-MNS 3384:1982. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS0017-2-5-11:1988. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга -Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих
Хөрсөнд										

**“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БУМБАТ-II” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН
“УЛААН-ӨНДӨР”-ИЙН ИЛ ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

4	Ашиглалтын үед	Хөрсний унаган төрхийг алдагдуулах	Шимт хөрсийг хуулж, тусгай талбайд стандартын дагуу байршуулах	Төслийн талбайд	-	8,000,000	-	8,078,500	Үйл ажиллагааны турш	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль -MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 4006:1987 Хөрс. MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга -MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
5			Тээврийн хэрэгслийн болон явган хүний зам, зогсоол байгуулах, тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, хаалт хамгаалалт хийх			4,357,000	1	4,357,000	Үйл ажиллагааны турш	
6			Гадаад болон дотоод тээвэр хийх үед олон салаа зам гаргахгүй байхад тогтмол анхааран ажиллах	Төслийн талбайд		3,178,500	1	3,100,000	Үйл ажиллагааны турш	
Усны нөөц, усны чанарт										
7	Ашиглалтын үед	Ус бохирдох, усны нөөц буурах	Ажилчидад усыг ариг гамтай хэрэглэх, хамгаалах тухай сургалт зохион байгуулах	Уурхайн нийт ажилчида д		1,443,000	1	1,443,000	1 удаа	

“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БУМБАТ-II” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН
“УЛААН-ӨНДӨР”-ИЙН ИЛ ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

8			Ажилчдын унд ахуйн усанд ашиглаж байгаа гүний худгаас дээж авч шинжилгээ хийлгэх	Ажилчдын байрны хүрээнд	-	-	-	-	Орчны хяналт шинжилг ээний зардалд	
Амьтны аймаг, ургамлан нөмрөг										
9		Хог хаягдлын индикатор амьтад үржих, хордох нөхцөл бүрдүүлэхгүй байх	Хог хаягдлыг ангилан ялгах хогын сав байршуулах	Төслийн талбайд	-	-	-	-	Хог хаягдлын зардалд	
Нийт 23,278,500										

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян,төг	Хэрэгжүүлэх хугцаа ба давтамж	Баримтлах эрх зүй баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	2026 онд биологын болон техникийн нөхөн сэргээлт хийгдэхгүй							“Байгаль орчныг хамгаалах тухай” “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” MNS5915:2008MNS5916:2008 MNS5917:2008
2	Биологийн нөхөн сэргээлт								
Нийт 0,0 сая.төг									

БҮЛЭГ 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

БҮЛЭГ 8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

БҮЛЭГ 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян\төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулан ажиллах	Уурхайн кемп	1	1,000,000	1000,000	Үйл ажиллагааны турш	
	Гамшигаас хамгаалах төлөвлөгөө батлуулан ажилуулах	Уурхайн кемп	1	1,500,000	1,500,000	Үйл ажиллагааны турш	
	Төслий талбайд болзошгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах.	Уурхайн кемп	1	700,000	700,000	Үйл ажиллагааны турш	
	Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, хамруулах	Уурхайн кемп	1	825,000	825,000	Үйл ажиллагааны явцад	
	Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулах мөрдөж ажиллах	Уурхайн кемп	1	1,400,000	1,400,000	Үйл ажиллагааны турш	
Нийт			5,425,000				

БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
Ахуйн болон хатуу хог хаягдал	Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар авах	Дундговь аймгийн байгаль орчин	-	-	-	-	Үйл ажиллагааны үед	- БОАЖ-ын сайдын 2018 оны А/443 тушаал Энгийн хог хаягдлыг ангилах,
	Газарт бага хэмжээний асгарсан тос, масло саармагжуулагч хийх	Уурхайн засварын талбайд	-	533,000	1	533,000	Үйл ажиллагааны үед	цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах,
	Хог хаягдлыг ангилан ялгах тухай сургалт нийт ажилчдад орох	Уурхайн ажилчдад		600,000	1	600,000	Үйл ажиллагааны үед	сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий
	Аюултай хог хаягдлын гэрээг мэргэжлийн байгууллагатай хийн хамтран ажиллах	Уурхайн кемп	-	1,000.000	1	1,000.000	Үйл ажиллагааны үед	шаардлага; БОАЖ-ын сайдын 2018 оны А/445 тушаал
	Хог хаягдлыг цуглуулах савыг агаар сайн нэвтэрдэг Байхаар хийх	Уурхайн кемп	-	1,500.000	1	1,500.000	Үйл ажиллагааны үед	Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан
	Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах.	Үйл ажиллагааны турш	-	700,000	1	700.000	Үйл ажиллагааны турш	заавар; БОАЖ-ын сайдын 2018 оны А/21 тушаал; MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
Нийт			4,333,000 төг					

БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж 2026 он	Давтам жийн тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Хөрсний бохирдол								
1	Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 4 цэг сонгох /Уурхайн кемп орчим, уурхайн ухаш/	Жилд 2удаа	Жилд 2 удаа	-	817,000	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	4цэгт /Засварын цех, ШТС/	Жилд 2удаа	Жилд 2 удаа	-	581,000	

**“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БУМБАТ-II” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН
“УЛААН-ӨНДӨР”-ИЙН ИЛ ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Усны хяналт шинжилгээ								
2	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	2026 он	Жилд 2 удаа	-	816,750	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3	Усны түвшин усны ундарга нөөц	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх	Гүний худгийн ус, Гол	2026 он				
4		Агаарт тоос босох	Уурхайн бүсэд	2026 он	Жилд 2 удаа		1,566,500	
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2026 ОНЫ ЗАРДЛЫН ДҮН							3,781,250	

**БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРЛАГА
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2026 он					
		I- улирал	II- улирал	III-улирал	IV-улирал		
Ажилчдад байгаль орчныг хамгаалах талаар сургалт зохион байгуулах		-	+	-	-	Байгаль орчны мэргэжилтэн	-MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн журам гарган ажилчдад мөрдүүлэн ажиллах.		+	+	+	+	Уурхайн дарга, хаб	
Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах		+	-	+	-	Захирал	
Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал		+	+	+	+	Захирал	
Гал түймрээс урьдчилан сэргийлэх багаж хэрэгсэл байрлуулах.		+	+	+	+	Захирал	

БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЯНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

БОМТ түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэрүүд	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах	Зохион байгуулах газар
Бомт-ийн биелэлтийг оршин суугчдад тайлагнах					
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Дундговь аймгийн Говь-Угтаал сумын засаг захиргааны байгууллагад танилцуулж, хэлэлцүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумдын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	БОМТ-ний хэрэгжилтийн явцад орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон оршин суугчдад танилцуулна.	Сумын засаг захиргааны удирдлага болон байгаль орчны байгууллагын санал, шүүмжийг хүлээн авч шийдвэрлэх	Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг захиргааны байранд
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутгийн оршин суугчдад танилцуулж хэлэлцүүлнэ.	Нутгийн оршин суугчдад БОМТ-ний биелэлтийг тайлагнах	БОМТ-ний биелэлт		Оршин суугчдын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	